



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 1110

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.3, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт оршин суух иргэн Мягмарсүрэнгийн Бат-Өлзий (ЙБ94070515)-ийн эзэмшиж буй 6221000295 нэгж талбарын дугаартай, гэр, орон сууц хашааны газрын зориулалт бүхий 1856 м2 газрыг иргэн Алтанхуягийн Чинзориг (ЙБ86123011)-д 40 жилийн хугацаатай газрыг эзэмших эрх шилжүүлэх гэрээг үндэслэн шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг Газрын даамал (Д.Оюунбилэг)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын "Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай" 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн а/142 дугаар захирамжийн М.Бат-Өлзийтэй холбогдох заалт, газрын гэрээ, гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН